



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**ӨРГӨН
НЭВТРҮҮЛГИЙН
ОРЧИНД ХҮҮХДИЙГ
ЗОХИСГҮЙ АГУУЛГААС
ХАМГААЛАХ
ЗӨВЛӨМЖ**

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар

2026 он



ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ОРЧИНД ХҮҮХДИЙГ ЗОХИСГҮЙ АГУУЛГААС ХАМГААЛАХ ЗӨВЛӨМЖ

(Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд)

Өнөө үед хүүхэд, өсвөр насныхан өдөр бүр мэдээллийн асар их урсгалтай нүүр тулж, дэлхийн хаанаас ч, хүссэн цагтаа төрөл бүрийн эх сурвалжаар дамжуулан мэдээ, мэдээлэл хүлээн авах боломжтой болсон нь өдөр тутмын амьдралынх нь салшгүй хэсэг болжээ. Мэдээлэл хүлээн авч буй орчин нь хүүхдийн мэдлэгийн хүрээг тэлэхийн зэрэгцээ тэдний хандлага, үнэт зүйл, зан төлөвт шууд болон шууд бусаар нөлөөлдөг. Мэдээллийн хүртээмж, нээлттэй байдал нэмэгдэж байгаатай зэрэгцэн хүүхдүүд нас, сэтгэхүйн онцлогтоо тохироогүй, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн агуулгад өртөх эрсдэл байсаар байна. Түүнчлэн далд сөрөг нөлөө бүхий агуулга нэмэгдэж, хүүхдийн сэтгэл зүй, зан төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй талаар сэтгэл судлал болон хүүхэд хөгжлийн судалгаануудад дурдахаас гадна сэтгэл судлаачдын зүгээс ч мэргэжлийн тайлан, нийтлэлүүддээ онцлон анхааруулах болсон.

Сошиал медиа, онлайн видео платформуудаас гадна өргөн нэвтрүүлгийн орчин, ялангуяа телевиз нь гэр бүлийн дундын, чухал мэдээллийн эх сурвалж хэвээр байгаа юм. Иймд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаандаа хариуцлагатай, мэргэшсэн, ёс зүйтэй байх зарчмыг баримтлан хүүхэд, залуучуудын хүмүүжил, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэх агуулга түгээхгүй байх үүргийг хэрэгжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Тиймээс аюулгүй, хариуцлагатай мэдээллийн орчныг бүрдүүлэх нь нэн чухал юм.

Зохисгүй, хүүхдэд сөрөг нөлөөтэй агуулгаар юуг хориглосон бэ?

- **Хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх агуулга:** Хүчирхийлэл, зодолдсон дүрслэл, хараал, бүдүүлэг үг хэллэг, аймшиг, сэтгэл түгшээх контент, гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нэвтрүүлэг, контент хийхээс зайлсхийнэ.

Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дуурайх, шүтэх өнгө аясаар нэвтрүүлэхгүй. Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй. Золгүй явдал, осол хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүр нь хүүхэд өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана. Мөрийтэй тоглоом тоглохыг уриалахгүй байх.

- **Садар самуун, Бэлгийн шинжтэй агуулга:** Насанд хүрэгчдэд зориулсан садар самуун, бие махбодын хэт ил, задгай дүрслэл бүхий контент нэвтрүүлэхгүй байх. Тайлбар:
 - Сүүлийн жилүүдэд хүүхдийн насанд тохирох мэт боловч далд байдлаар насанд хүрэгчдийн харилцаа, бэлгийн шинж чанартай агуулгыг багтаасан ёс суртахууны төөрөгдөл бүхий контент нэмэгдсэн. Америкийн Сэтгэл судлалын холбоо (APA) судалгаагаар ийм контент үзсэн өсвөр насныхны дунд биеийн талаарх сөрөг ойлголт, өөрийн үнэлэмж буурах, бэлгийн сонирхол эрт хөгжих хандлага хоёр дахин өндөр байжээ.
- **Архи, тамхи, мансууруулах бодисыг хэрэглээг сурталчилсан агуулга:** Согтуурсан, мансуурсан байдлыг харуулахгүй байх, мансууруулах үйлчилгээ бүхий ургамал, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэн боловсруулах, хэрэглэхийг харуулахгүй. Архи, тамхины хэрэглээг сурталчилсан нэвтрүүлэг, контент болон зар сурталчилгаа үүнд хамаарна.
- **Амиа хорлолт, өөртөө гэмтэл учруулах тухай агуулга:** Хүүхдийн эрүүл мэндэд хохирол учруулахуйц агуулга буюу амиа хорлолт, хэрхэн амиа хорлох тухай агуулгыг харуулахгүй байх;
- **Ялгаварлан гадуурхалт, үзэн ядалтыг харуулсан агуулга:** Яс үндэс, арьс өнгө, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал зэргээр ялгаварлан гадуурхах, бусдыг айлган сүрдүүлэх, зодох, дооглох, тохуурхах, гадуурхах, нэр хоч өгөх зэргээр ичээх, гутаах, доромжлох зэргийг харуулахыг хязгаарлана.

Хүүхэд зохисгүй агуулгад өртөх эрсдэл, сэтгэлзүйн сөрөг нөлөөлөл

Хориотой болон хортой агуулга нь хүүхдийн сэтгэл зүй, зан төлөвт дараах сөрөг нөлөөллийг үзүүлэх эрсдэлтэй. Үүнд:

- Түрэмгий зан төлөв, даган дуурайх хандлага нэмэгдэх;
- Айдас, түгшүүр, стресс үүсэх;
- Нойрны хэмнэл алдагдаж хямрах, сэтгэлзүйн тогтворгүй байдал үүсэх;
- Хараал, бүдүүлэг үг хэллэгийг хэвийн хэрэглээ мэт хүлээн авах, улмаар хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх;
- Эрсдэлтэй зан үйлд суралцах давтамж ихсэх тусам “хэвийн мэт” хүлээн авах хандлага бүрэлдэх.

Түрэмгий зан үйлд нөлөөлөх хүчин зүйлс

Хүүхэд, өсвөр үеийнхэн дараах нөхцөлд түрэмгий зан үйлийг илүүтэй дуурайх хандлагатай байдаг. Үүнд:

- Түрэмгий үйлдэл хийж байгаа дүр эерэг, гадаад үзэмж тааламжтай (царайлаг, хөөрхөн, хүчтэй гэх мэт), сонирхол татахуйц байдлаар дүрслэгдсэн;
- Түрэмгий, харгис, хүчирхийллийн үйлдлийг зөвтгөсөн утга агуулсан (муу хүн учраас зодуулах ёстой гэсэн санаа агуулсан гм);
- Зэвсэг, хүч хэрэглэсэн үйлдэл давамгайлсан;
- Түрэмгийлэл, харгис үзэгдэл ил тод, бодит мэт дүрс бичлэгтэй;
- Түрэмгий, харгис үйлдлийг шагнаж, сайшаасан байдлаар харуулсан;
- Түрэмгий, харгис үйлдлийг хөгжилтэй, хошин байдлаар илэрхийлж хүмүүс инээж, таатай байдлаар хүлээн авч байгаа зэргээр сөрөг үр дагаврыг бүдгэрүүлсэн илэрхийлэлтэй гм;

Эрсдэлд илүү өртөмтгий хүүхдийн бүлэг

Түрэмгийлэл, хүчирхийлэл бүхий агуулгад сэтгэл зүйн болон нийгмийн эмзэг байдлын хүчин зүйлсээс хамааран хүүхдүүдийн өртөмтгий байдал харилцан адилгүй байдаг. Дараах хүүхдүүд эрсдэлд илүү их өртдөг болохыг судалгаагаар тогтоожээ. Үүнд:

- Сэтгэл зүйн гэмтэл аль хэдийн авсан;
 - Суралцах чадвар доголдсон;
 - Гэр бүлийн хүчирхийлэл, хэрүүл маргааны асуудалтай;
 - Гэр бүлийн сэтгэлзүйн дэмжлэг, харилцааны эерэг орчин дутмаг, үл ойлголцол бүхий орчинд өсөж буй;
- Нийгмийн болон соёлын ялгаатай орчинд дасан зохицох хүндрэлтэй (Яс, үндэс, шашин шүтлэг өөр гэр бүлийн хүүхдүүд);

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах хууль, эрхзүйн зохицуулалт ба хариуцлага

Хүүхдийн сэтгэл зүй, зан төлөвт зохисгүй агуулгын үзүүлэх сөрөг нөлөөллийг харгалзан үзэхэд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн үүрэг, хариуцлага онцгой ач холбогдолтой юм. Иймд хууль тогтоомжид хүүхдийг хамгаалахтай холбоотой дараах үндсэн шаардлагуудыг тусгасан. Үүнд:

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь

- ✓ хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх бүх төрлийн хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаалах;
- ✓ өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх;
- ✓ контент, бүтээлийг олон нийтэд түгээхийн өмнө насны ангиллын тэмдэглэгээг байршуулах;
- ✓ хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эдгээр шаардлага нь хүүхдийн эрх ашгийг хамгаалах, мэдээллийн аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаандаа заавал мөрдлөгө болно.

Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага:

Хүүхдийн сэтгэл зүйн хөгжил, ёс суртахууны төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх агуулгыг Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээгээр түгээх нь дараах хууль тогтоомжийг зөрчсөнд тооцогдоно. Үүнд:

- “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн 25.1, 25.5, 25.7;
- “Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулийн 5.1.8, 23.9, 27.1.1;
- “Кино урлагийг дэмжих тухай” хуулийн 21.2;
- “Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн” 5.1, 8.1.2;
- Зар сурталчилгааны тухай хуулийн 6.5 дугаар зүйлд заасныг **зөрчсөн үйлдэлд тооцогддог.**

Зохисгүй агуулга нэвтрүүлсэн тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хорооны дэргэдэх Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах орон тооны бус зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх ба зөрчлийг давтан гаргавал “Зөрчлийн тухай хууль”, “Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн дагуу арга хэмжээ авах зохицуулалттай. Иймд Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч та бүхэнд дараах зөвлөмж, зөвлөгөөг хүргэж байна.

ЗӨВЛӨМЖ

- Өөрийн редакцын бодлого, дүрэмтэй байх, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;
- Редакцын бодлогодоо зохисгүй агуулгын хэм хэмжээг хууль, дүрэм журамд зааснаар тодорхойлж тусгах;
- Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах Радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийг мөрдөх
- Редакцын түвшинд агуулгын хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Хортой, зохисгүй агуулгыг хяналтгүйгээр түгээхээс урьдчилан сэргийлэх;
- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх тодорхой журамтай байх;
- Илэрсэн зөрчилд дотоод хяналт, засвар, сайжруулалтын арга хэмжээ авч хэвших.

Мөн дараах ёс зүйн зарчмуудыг өдөр тутамдаа ашиглахыг зөвлөж байна.



Зураг: Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжөөс, редакцын бодлогодоо тусгах нь

✚ Насны ангилал, тэмдэглэгээг стандартын дагуу байршуулах

- Контентын насны ангиллыг тогтоох дотоод механизм, эсхүл хариуцсан нэгжтэй байх (Насны ангилал тогтоох зөвлөлтэй байх);
- Насны ангиллын тэмдэглэгээг стандартын дагуу зөв, ойлгомжтой байршуулж, радиогийн хувьд эхлэл хэсэгт дуугаар, телевизийн кино, нэвтрүүлэгт нэвтрүүлгийн туршид дүрсээр илэрхийлэх;

✚ Зохисгүй агуулгыг хянах

➤ Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид

- ⊖ Зохисгүй агуулга нэвтрүүлэхгүй байх, хяналт тавих;
 - Хараал, бүдүүлэг үг хэллэг, хүчирхийллийг өөгшүүлсэн яриаг нэвтрүүлэхгүй байх;
 - Хүүхдийн сувгууд 18+ контент нэвтрүүлэхгүй байх;
 - Хүүхдийн нэвтрүүлгийн дундуур чихэр/давс/транс/ханасан тос ихтэй бүтээгдэхүүн сурталчлахгүй байх;
- 🕒 Хүүхдийн нэвтрүүлгийг 21:00-аас хойш дамжуулахгүй;
 - 18+ контентыг 06:00–22:00 цагт нэвтрүүлэхгүй, давтан дамжуулахгүй;
- 🔇 Зохисгүй дуу, авиа, бүдүүлэг ёс зүйгүй үг хэллэгтэй хэсгийг устгах, дууг хаах, дуут сигналаар орлуулах зэрэг техникийн арга хэмжээ авах;
- 👤 Хүүхэд оролцсон контентыг хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хяналттай бэлтгэх;
- 📺 Радиогоор нэвтрүүлэх зохисгүй үг хэллэгтэй дуу, хөгжимд хяналт тавих;

➤ Олон сувгийн үйлчилгээ эрхлэгч

- 🔒 Насанд хүрэгчдэд зориулсан тохиргоо (parental control)-г идэвхжүүлэх, хязгаарлах, хаах боломжийг бүрдүүлэх;
 - Хүүхдэд тохиромжгүй контентын трейлерийг нээлттэй орчинд автоматаар тоглуулахыг хориглох, трейлерийг үзүүлэхдээ хэрэглэгчээс нас баталгаажуулах эсхүл PIN код шаардах техникийн хязгаарлалтыг заавал хэрэгжүүлсэн байна.
 - 18+ насны ангилалд хамаарах контентын танилцуулга зураг нь ил тод байдлаар харагдахгүй байх.
- ⊖ Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдэлд заасан хориотой, хүүхдэд хортой агуулгыг өөрийн үйлчилгээнд хязгаарлах, хаах үүрэгтэй.

Зар сурталчилгаа нэвтрүүлэхдээ юуг анхаарах вэ?

- Зар сурталчилгаа нь зөвхөн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах хэрэгсэл бус, хүүхдийн ойлголт, хандлага, зан төлөвт нөлөөлөхүйц агуулга гэдгийг харгалзан үздэг байх;

- Хүүхэд нь нас, сэтгэхүйн онцлогоос шалтгаалан зар сурталчилгааны агуулгыг шүүлтүүртэйгээр хүлээн авдаг ба ялган тунгаах чадвар нь бүрэн төлөвшөөгүй байдаг тул эрүүл мэнд, ёс суртахуун, төлөвшил, хэрэглээний зан төлөвт нь сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бодолцох;
- Хүүхдэд чиглэсэн, эсхүл хүүхдийн сэтгэлзүй, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй сурталчилгааг нэвтрүүлэхээс өмнө хүүхдийн хөгжил, сэтгэлзүйн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнээс зөвлөмж авах нь зүйтэй.

Мөн хүүхдэд чиглэсэн болон хүүхэд үзэх боломжтой орчинд түгээж буй зар сурталчилгаанд дараах зарчмыг баримтлан хяналт тавих. Тухайлбал,

- боловсролын болон эерэг хандлага төлөвшүүлэх агуулгатай байх;
- эрүүл бус хүнсний хэрэглээг сурталчилсан агуулгыг аль болох хязгаарлах,
- биеийн төрхийг шүтсэн, материаллаг хэрэглээг дөвийлгөсөн агуулгыг хязгаарлах;
- Кино, нэвтрүүлгийн сурталчилгаа, трейлерт хориглосон агуулга оруулахгүй байх;

Контентыг хүүхдэд ээлтэй, сэтгэл зүйд нь хор хөнөөлгүй, танин мэдэхүй, хүмүүжилд нь эерэг нөлөөтэй байхаар төлөвлөж хүргэх нь зөвхөн ёс зүйн асуудал бус, хүүхдийн хөгжил, нийгмийн ирээдүйд чиглэсэн чухал хөрөнгө оруулалт юм.

Хүүхэд бол өнөөдрийн үзэгч, контент хэрэглэгч төдийгүй ирээдүйн эцэг, эх, иргэн, нийгмийн нэг гишүүн болох тул хүүхдэд чиглэсэн агуулга, контентын чанар, хариуцлагад онцгой анхаарах шаардлагатай.



ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР